13.3 Төгсөлт баталгаажуулах хүсэлт илгээх

Төгсөлт баталгаажуулах хүсэлт илгээх

Энэ үйлдлийг бүлгийн нийт суралцагчдын төгсөлтийн бүртгэлийг баталгаажуулах хүсэлтийг илгээх үед ашиглана.

ТӨГСӨЛТ БАТАЛГААЖУУЛАХ ХҮСЭЛТ ИЛГЭЭХЭЭС ӨМНӨ ДАРААХ АЖЛУУД СИСТЕМД ХИЙГДСЭН БАЙХ ШААРДЛАГАТАЙ.

1. Суралцагчийн төгсөлтийн бүртгэл хийсэн байх

2. Зөвхөн баталгаажуулсан төгсөлтийг цуцлах боломжтой.

Сургалтын менежер анги удирдсан багшийн илгээсэн суралцагчийн төгсөлтийн баталгаажуулах хүсэлт илгээх үйлдэл хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. Төгсөлт үйл ажиллагааг сонгоно.

2. Төгсөлт баталгаажуулах хүсэлт илгээх бүлгийг сонгоно.

3. Төгсөлтийн бүртгэл баталгаажуулах суралцагчийг чеклээд **Баталгаажуулах хүсэлт** товч дарна.

Суралцагчийн төгсөлтийг баталгаажуулах/цуцлах алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Төгсөлт**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

Төгсөлт цонхны зүүн хэсэгт байрлах талбараас төгсөлтийн баталгаажуулалт хийх бүлгийн мэдээллийг сонгоод баруун дээд хэсэгт байрлах **төгсөлтийн бүртгэл** үйлдлийг дарахад төгсөлтийн бүртгэлийн дараах цонх нээгдэнэ.

Төгсөлтийн бүртгэл цонхонд тухайн бүлгийн төгсөлтийн бүртгэл хийсэн нийт суралцагчийн жагсаалт гарч ирэх бөгөөд төгсөлт баталгаажуулах/цуцлах суралцагчийн урд талыг чеклээд **Баталгаажуулах хүсэлт** товчийг дарахад **Хянагдаж буй** төлөвтэй болно.

Анхаарах зүйлс: Хэрэв 5-р ангийн анги удирдсан багшийн эрхээр нэвтэрсэн бол **баталгаажуулах хүсэлт** гэсэн нэртэй товч байх бөгөөд баталгаажуулах хүсэлт илгээж, эрхлэгчийн эрхээр нэвтэрч дээрх цонхноос баталгаажуулах/цуцлах үйлдэл хийнэ. Мөн эрхлэгчийн эрхээр нэвтэрч шууд баталгаажуулах боломжтой.

Харин 9 болон 12-р ангийн анги удирдсан б